



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 05 сарын 20 өдөр

Дугаар 088

Жавхлант

Хяналтын ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалын (орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам) 3 дугаар зүйлийн 3.4.3, дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Гудамж талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх ажлыг гүйцэтгэлд хяналт тавих ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Г.Энхзаяа

Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга:

П.Эрдэнэчимэг

Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн

Гишүүдэд:

Г.Батсайхан

Нярав

2.Захиалагчийн ажлын даалгавар, техникийн тодорхойлолтод үндэслэн ажлын эхлэл, явц, гүйцэтгэлд хяналтыг тавьж, зургаар баталгаажуулж, хурлын тэмдэглэл үйлдэн, тайланг ирүүлэхийг Ажлын хэсгийн ахлагч (Г.Энхзаяа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.БАТЧУЛУУН